

**“Айтүүлс” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлан**

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>	
Тайлагнах хугацаа	2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Айтүүлс ХК, 9010001141, 543, 75755585
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Стандарт инвестмент ҮЦК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээллийн технологи, харилцаа холбоо
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Сэрэлт дөл аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	34,452,124
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Нягтлан бодогч Б.Өнөрбадрах
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	<a href="#">Тайланг хавсаргаав</a>
Орлогын тайлан	<a href="#">Тайланг хавсаргаав</a>
Өмчийн өөрчлөлтийн тайлан	<a href="#">Тайланг хавсаргаав</a>

Мөнгөн гүйлгээний тайлан	<a href="#">Тайланг хавсаргаав</a>
1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<a href="#">Аудитын дүгнэлт хавсаргаав.</a>
1.2. Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	<a href="#">Аудитын дүгнэлт хавсаргаав.</a>
2. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ - 1.01% Нийт эздийн өмчийн өгөөж /ROE/ - 1.19%
2.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа – 7.44%
2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал юм. Энэхүү гол зорилгынхоо хүрээнд бид 2021 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан.

		<ol style="list-style-type: none"> <li>1. Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх</li> <li>2. Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх</li> <li>3. Харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх</li> </ol>
2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5.	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	Тайлант хугацаанд 997,000,000 /есөн зуун ерэн долоон сая/ төгрөгийн зээл авсан болно.
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	<p>Айтүүлс ХК-ийн 2021 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Ай Си Ти групп ХК-тай “Зээлийн гэрээ” байгуулсан.</p> <p>Сонирхлын зөрчилтэй этгээд: “Ай Си Ти групп” хаалттай хувьцаат компани /5721261/ нь Айтүүлс ХК-ийн 39%-ийн хувьцаа эзэмшдэг болно.</p>	
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>	
	<i>Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд 2021 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан төсвийн дагуу цалин урамшуулал олгосон.</i>	
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	

	<p>Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу аудитын, цалин, урамшууллын нэр дэвшүүлэх хороодоос гадна Мэдээллийн аюулгүй байдлын болон Бизнес хөгжлийн хороог дэргэдээ байгуулан ажиллаж байна. Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг болон бусад нарийвчилсан заалтуудыг оруулан шинэчлэн найруулсан. Мөн компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг хянах болон бодлого, стратегийг тодорхойлох, Гүйцэтгэх удирдлагад стратегийн удирдамж чиглэлээр ханган ажиллаж байна.</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд</li> <li>ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир</li> <li>ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амгаланбаатар</li> <li>ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Улаанхүү</li> <li>ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Эрдэнэжаргал</li> <li>ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Тамир</li> <li>ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Мягмарсүрэн</li> <li>ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа</li> <li>ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Жавхлан</li> </ol> <p>Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Бизнес хөгжлийн хороо нь компанийн “Бизнес төлөвлөгөө” боловсруулахад болон компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, борлуулалт стратеги төлөвлөлт дээр Гүйцэтгэх удирдагач зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэн ажилласан.</p>
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Байхгүй
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй болно.</p> <p>2022 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 1561 хүн Айтүүлс ХК-ийн хувьцаа эзэмшиж байна. Үүнээс дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нар байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ай Си Ти групп ХК – 39.82%</li> <li>2. Стандарт инвестмент ҮЦК ХХК – 10.38%</li> <li>3. AFC Umbrella FUND-AFC Asia Frontier – 13.48%</li> </ol>

8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>
	<i>2021 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй</i>
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>
	<i>2021 онд ногдол ашиг хуваарилаагүй болно.</i>
10.	<i>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</i>
	<i>Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажил байхгүй болно.</i>



“АЙТҮҮЛС” ХК-ний  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;  
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2022.02.17 № СТБ/22-06

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**Дүгнэлт**

Бид “Айтүүлс” ХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид “Айтүүлс” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой.

## **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

## **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

#### Бусад зүйлс

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн [Хувьцаа эзэмшигчийн захиалсан](#) аудиттай холбогдуулан “Айтүүлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

“СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ” ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид



/Д.АЛТАНЦЭЦЭГ/  
Захирал, МНБ

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2022 оны 02-р сарын 17.



## Санхүү байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2020.12.31	2021.12.31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	174,871,478.58	250,132,657.85
1.1.2	Дансны авлага	656,547,692.75	518,226,897.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	1,530,776.06	29,664,162.05
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	95,316,936.94	114,587,989.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	146,386.00	113,045,953.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10	...	0.00	0.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>928,413,270.33</b>	<b>1,025,657,659.55</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,465,430,943.20	3,497,288,616.25
1.2.2	Биет бус хөрөнгө	91,760,397.93	45,443,051.07
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145.00	70,446,145.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,008,172,180.44	0.00
1.2.9	...	0.00	0.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,635,809,666.57</b>	<b>3,613,177,812.32</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,564,222,936.90</b>	<b>4,638,835,471.87</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1.1	Дансны өглөг	41,334,801.20	115,806,636.07
2.1.1.2	Цалингийн өглөг	551,195.97	0.00
2.1.1.3	Татварын өр	59,988,876.23	22,141,375.74
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12	...	0.00	0.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>101,874,873.40</b>	<b>137,948,011.81</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>997,000,000.00</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	997,000,000.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00

2.1.2.5	...	0.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>997,000,000.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>101,874,873.40</b>	<b>1,134,948,011.81</b>
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	1,481,441,363.28	1,481,441,363.28
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	763,114,860.00	763,114,860.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652.19	460,721,652.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	757,070,188.03	798,609,584.59
2.3.10	...	0.00	0.00
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,462,348,063.50</b>	<b>3,503,887,460.06</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>3,564,222,936.90</b>	<b>4,638,835,471.87</b>

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>3,234,368,647.18</b>	<b>2,546,825,167.74</b>
2	Борлуулалтын өртөг	2,282,146,791.96	1,574,491,854.53
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>952,221,855.22</b>	<b>972,333,313.21</b>
4	Түрээсийн орлого	19,545,454.55	20,681,818.19
5	Хүүгийн орлого	629,610.77	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	5,321,428.51	4,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	648,966,833.92	931,434,739.58
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	31,197,608.37	18,838,705.67
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	2,176,263.83	1,506,388.44
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	-4,301,600.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз )	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал )	0.00	0.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>295,428,570.59</b>	<b>48,248,074.59</b>
19	Орлогын татварын зардал	32,662,617.90	6,708,678.03
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>262,765,952.69</b>	<b>41,539,396.56</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
22	<b>Тайланг үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>262,765,952.69</b>	<b>41,539,396.56</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз ( гарз )	0.00	0.00
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>262,765,952.69</b>	<b>41,539,396.56</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

### Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	494,304,235.34	3,199,582,110.81
2	Тягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	494,304,235.34	3,199,582,110.81
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	262,765,952.69	262,765,952.69
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	757,070,188.03	3,462,348,063.50
10	Тягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	757,070,188.03	3,462,348,063.50
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	41,539,396.56	41,539,396.56
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,481,441,363.28	0.00	763,114,860.00	460,721,652.19	0.00	0.00	798,609,584.59	3,503,887,460.06

## Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,905,335,309.92	2,609,282,056.37
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	2,895,476,128.70	2,599,509,329.10
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,859,181.22	9,772,727.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,598,798,888.45	2,309,421,367.07
1.2.1	Ажилагсад төлсөн	269,446,402.79	381,183,395.14
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	34,301,634.22	107,054,285.88
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,962,156,856.69	1,428,449,309.68
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	2,849,051.80	44,964,808.58
1.2.6	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	1,695,809.53
1.2.7	Хүүний төлбөрт төлсөн	0.00	105,239,999.99
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	152,837,569.26	93,057,536.42
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	450,000.00	0.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага	176,757,373.69	147,776,221.86
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	306,536,421.47	299,860,689.30
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,149,088,862.26	409,644,565.17
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	16,500,000.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	0.00	0.00
2.1.5	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,131,959,251.49	409,644,565.17
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	629,610.77	0.00
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,329,728,945.84	1,591,418,097.36
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	130,222,586.70	1,478,454,610.77
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	1,199,506,359.14	112,963,486.59
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-180,640,083.58	-1,181,773,532.19
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	116,875,898.54	1,044,670,052.21
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	114,365,256.00	1,043,000,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	1,670,052.21
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	142,449,817.43	87,496,030.05
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	142,265,256.00	87,334,801.20
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,326,081.11	161,228.85
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-27,900,000.00	957,174,022.16
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	97,996,337.89	75,261,179.27
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,549,059.58	174,871,478.58
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	174,871,478.58	250,132,657.85